




2016 оны 4-р сарын 9-ний өдрийн БНН-ын
Бага хурлын 06 тоот тогтоолоор батлав.



**БҮГД НАЙРАМДАХ НАМЫН
2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН
“ХҮЧИРХЭГ, ХӨГЖИНГҮЙ МОНГОЛЫН ТӨЛӨӨ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Намын уриа:

**“УЛС МОНГОЛДОО – ХҮЧТЭЙ ТӨР
АРД ТҮМЭНДЭЭ – ЧИНЭЭЛЭГ АМЬДРАЛ
ЭХ НУТАГТАА – УНАГАН ТӨРХ”**

**Улаанбаатар
2016 он**

АГУУЛГА:

Нэг	Улс төрийн бодлого – Хүчтэй төр
Хоёр	Нийгмийн бодлого – Иргэн бүрт
Гурав	Эрүүл мэндийн бодлого – Монгол хүний төлөө
Дөрөв	Шинжлэх ухаан, боловсрол, соёл – Хөгжлийн түлхүүр
Тав	Эдийн засгийн бодлого – Хөгжлийн ирээдүй
Зургаа	Үйлдвэржилт – Амьдралын баталгаа
Долоо	Хөдөө Аж Ахуй – Аюулгүй хүнс
Найм	Дэд бүтэц, Ардын орон сууц – Аз жаргалтай амьдрал
Ес	Байгаль орчин – Ногоон ирээдүй
Арав	Батлан хамгаалах – Сайн хөршийн түншлэл
Арван нэг	Гадаад харилцаа – Хамтын ажиллагаа

ОРШИЛ

Монгол Улс болон Үндэстнийхээ эрх ашгийг дээдэлж, хувь хүний эрх, эрх чөлөө, эрүүл, аз жаргалтай амьдрал, өрх гэр болгоны сайн сайхны төлөө чармайн тэмцэхээ илэрхийлэн, шудрага хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх их зорилгоо тодорхойлохын зэрэгцээ Монгол Улсын хөгжил, улс төр, эдийн засаг, нийгмийг эрүүл шинэ бодлогоор бүрэн хангаж Монгол төрийг бэхжүүлэн хүчирхэг Монгол Улсыг байгуулахдаа “МОНГОЛ ХҮН” –ийг бодлогынхоо төвд ямагт байлгаж, авьяас билгээ хөгжүүлэх, бүтээлч, шударга хөдөлмөрөөрөө хувийн өмчөө арвижуулан, үндэсний баялгаа нэмэгдүүлж Монгол хүний амьдралын баталгааг бүрэн хангах зорилгоор “**ХҮЧИРХЭГ, ХӨГЖИНГҮЙ МОНГОЛЫН ТӨЛӨӨ**” ХӨТӨЛБӨР –өө Бүгд Найрамдах Нам ард түмэндээ өргөн барьж байна.

НЭГ. УЛС ТӨРИЙН БОДЛОГО – ХҮЧТЭЙ ТӨР

Монгол Төрийн дээр нам, намын нэрээр халхавч хийсэн бүлэглэл дарангуйлсан нийгмийн тогтолцоо, дүр эсгэсэн ардчилалаас УЛС МОНГОЛОО аварч, аз жаргалтай Монгол хүний чинээлэг амьдралын төлөө үйлчилдэг хүчтэй төрийг байгуулна.

Үүнд:

- БНН Үндсэн хуулиар олгогдсон монгол хүний бүрэн эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхийн төлөө тууштай хүчин зүтгэнэ.
- Аз жаргалтай Монгол хүний чинээлэг амьдралын төлөө үйлчилдэг хүчтэй төрийг байгуулна.
- Ардчиллын үнэт зүйл болох эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдэлийг төрийн үйл ажиллагаанд бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийг зорилгоо болгоно.
- Бүх шатны сонгуулийг ард түмний хяналтан дор ил тод, шудрага ардчилсан зарчмаар явуулж, хариуцлагатай улс төрийн тогтолцоог бий болгоно.
- Төрийн албыг намын нөлөөллөөс ангид байлгах, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх, тэдний нийгмийн баталгааг бэхжүүлэх, тогтвортой ажиллах эрх зүйн орчинг баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Улс төрийн намуудын үйл ажиллагаанд ард иргэдийн хяналтыг тогтоож, хатуу гишүүнчлэлгүй болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГО – ИРГЭН БҮРТ

Хөдөлмөрийн насны бүх иргэдээ ажлын байраар хангаж, тэдний бодит орлого хангалуун амьдрахад нь хүрэлцэхүйц байх, насанд хүрээгүй хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилгот бүлэгт чиглүүлэн дэмжих нь бидний тэргүүн зорилтын нэг байх болно.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж зааснаар Монгол хүндээ түүний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийг өөрсдийн үүргээ гэж ухамсарлан хэрэгжүүлнэ.

Үүний тулд:

- Төрийн бүх шатны нийгэм эдийн засгийн бодлоготой холбогдсон шийдвэр нь Үндсэн Хуульд заасны дагуу бүх хүн тэгш эрхтэй байх зарчмыг баримтлана
- Ажилгүйдлийг тууштай бууруулах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.
- Улаанбаатар хот болон төв суурин газруудын утаа, хог, ус, хөрсний бохирдолт, замын түгжрэлтэй тэмцэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- Зарим их, дээд сургуулиудыг Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг хотуудад шилжүүлэн, багш, оюутны хотхон байгуулж, тэдний ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Ядуурлын эсрэг дайн зарлан, чинээлэг дундаж давхаргыг 80 хувьд хүргэж, нийгмийн зонхилох хэсэг болгох нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцдог тогтолцоонд шилжиж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эдийн засгийн орчинг бүрдүүлнэ. 40-өөс дээш насны хүмүүсийн ажил эрхлэлтийг дэмжих бодлого явуулна
- Нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог боловсронгуй болгож, ҮНБ, ДНБ-ний өсөлттэй оновчтой уялдуулан нэмэгдүүлж, төрөөс үзүүлэх тэтгэмжийг олон хүүхэдтэй ядуу гэр бүл, хүн амын орлого багатай болон дундаж орлоготой хэсэг бүлэг рүү чиглүүлнэ.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО – МОНГОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ

Шударга өрсөлдөөн, чөлөөт сонголтод суурилсан, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох нь эрүүл мэндийн салбарын үндсэн зорилт мөн.

Эрүүл мэндийн салбарын анхан шатны байгууллага, эрүүл мэндийн даатгалын салбар, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зорилгоор:

- Эрүүл мэндийн даатгалын загварыг шинэчилж эх орондоо чанартай оношлогоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэнэ.
- Эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгосноор хүн болгон даатгалд хамрагддаг, түүгээрээ дамжуулан оношлогоо, эмчилгээгээ үнэ төлбөргүй хийлгэх боломжоор хангана.
- Эмнэлэг, үндэсний төвүүдийн санхүүгийн бие даасан үйл ажиллагааг хангаж, эмч, сувилагчдын ажлын ачаалал, ур чадварт суурилсан цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.
- Монгол хүнийг эрүүлжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж иргэн бүрийг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулан халдварт өвчин, тухайлбал сүрьеэ, шар, арьс өнгөний өвчний тархалтыг бууруулах дорвитой арга хэмжээ авна.
- Иргэдийг цахим карт, хувийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сантай болгож, эрүүл мэндийн даатгалтай иргэн харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах боломжоор хангана.
- Эмнэлгийн яаралтай тусламжийн нэгдсэн сүлжээ бий болгож, алсын дуудлагад бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах нөхцөлийг бүрдүүлж, явуулын болон сэхээн амьдруулах тасгуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Улаанбаатар хотын дүүрэг, аймгийн төвүүдэд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий оношлогооны төвүүд, төрөх эмнэлгүүдийг барина.
- Нэг сувилагчид ногдох өвчтөний тоог олон улсын жишигт хүргэж өвчтөнд үйлчлэх асаргаа, сувилгааны чанар, хүртээмжийг дээшлүүлэнэ. Анагаахын боловсрол олгох, мэргэшил дээшлүүлэх, нарийн мэргэшлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- Эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- Эм биобэлдмэлийн худалдаанд хатуу хяналт тогтооно.
- Спорт, чөлөөт цаг, эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлж элдэв төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэхэд хүн амыг бүрэн хамруулахад анхаарч ажиллана.
- Өндөр хөгжилтэй орны Анагаахын Шинжлэх Ухаан, техник технологийн ололтыг Монголд нэвтрүүлэх ажлыг системтэйгээр эхлүүлнэ.
- Хөгжингүй орны нарийн мэргэжлийн эмнэлгийн салбаруудыг Монголд хамтран байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Нийгмийн эрүүл мэндийн хүрээнд иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийг эрүүлжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Эрүүл, зөв хооллолт, урт насжилт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ, СОЁЛ – ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР

Агуу их түүхт монгол түмнийхээ соёлыг өвлөсөн, эх оронч, эрүүл саруул, элгэн нутгаа чин зүрхнээсээ хайрладаг хойч ирээдүйгээ бэлтгэх нь манай намын нэгэн эрхэм зорилго билээ.

Олон улсын стандартад нийцсэн, өндөр боловсролыг эх орондоо олж аваад эзэмшсэн мэргэжлээрээ хаана ч хөдөлмөр эрхлэх боломжтой байж, эх орныхоо ирээдүйн төлөө зүтгэх монгол хүнээ сургаж бэлтгэх нь манай намын боловсролын салбарын гол зорилт байна.

- Улсынхаа хөгжлийн загварыг зөв сонгож, эдийн засгаа оновчтой авч явахад манай эрдэмтэн мэргэдийн үүрэг асар их бөгөөд шинжлэх ухааны хөгжилд зарцуулах хөрөнгийн хэмжээг эрс нэмэгдүүлнэ.
- Энэ чиглэлд сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хангана.
- Дэлхийн шилдэгт тооцогддог Их сургуулиудтай хамтарч ажиллах урт хугацааны хөтөлбөрийг байгаль, хүмүүнлэг, эдийн засаг, хэрэглээ болон инженерчлэлийн бүх салбарт хөгжүүлэхийг чухалчилан анхаарна.
- Шинжлэх ухааны академи болон Их, дээд сургуулиудыг улс төрийн лоббиноос хамгаалах. Өндөр мэдлэг шаардсан шинжлэх ухаан болон их, дээд сургуулиудын салбарт удирдах зөвлөлийн гишүүн нэрийн дор улс төрийн лобби явагдахыг үл зөвшөөрнө. Шинжлэх ухааныг улс төрөөс хараат бус байх тогтолцоог бүрдүүлнэ.

Үүний тулд:

- Эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг монгол бахархалтай, үндэсний өв, соёл уламжлалыг дээдэлсэн иргэн болгон хүмүүжих нөхцөлийг хангана.
- Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, өргөтгөх замаар хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлнэ.
- Мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглаж, сурах бичиг, видео хичээл, танин мэдэхүйн цахим хуудас нээж ажиллуулна.
- Ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хамруулна.
- Ерөнхий боловсрол бол нийтийн асуудал, төрийн үйл хэрэг. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын боловсролыг нэг стандарт хөтөлбөрт оруулж, хүүхдийн хүмүүжлийг сайжруулах асуудлыг төрөөс чухалчилан анхаарна.

- Их, дээд сургуулийн тоог бус чанарыг чухалчилж, шинэ стандарт мөрдүүлэх замаар их, дээд сургуулийн чанарыг дээшлүүлнэ.
- Өндөр хөгжилтэй оронд сургах оюутан, докторантын тоог нэмэгдүүлэх хөтөлбөрийг дэмжинэ.
- Их, дээд сургуулиудыг түшиглэн өндөр технологийг дэмжих сургалтыг бий болгож, энэ салбарт суралцагсдын тоог нэмэгдүүлэн, гадаад орнуудтай оюутан, багш солилцох ажлыг өргөжүүлнэ.
- Монгол орны хөгжилд нэн шаардагдаж байгаа мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн гаргаж дэлхийн шилдэг их, дээд сургуулиудад оюутан сургана.
- Мэдээлэл холбоо, нано болон биотехнологийн чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлж, оюутан солилцооны шугамаар оюутнуудаа гадаадад сургах зэрэг ажлыг зохион байгуулна.
- Орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон судалгаа шинжилгээний нэгдсэн лабораторийн төвийг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дунд байгуулах бодлого баримтална.
- Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг зориулалтын сурах бичиг, тоног төхөөрөмжөөр хангаж, коллеж, их, дээд сургуульд элсэн суралцах боломжийг дээшлүүлнэ.
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг бүсчилж, мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан төгсөгчдийг ажлын байраар хангана.
- Их дээд сургуулиудын сургалтын материаллаг бааз бэхжүүлэх ажлыг дэмжиж архигүй, эрүүл, оюунлаг оюутныг дэмжих бодлого баримтлана.
- Байгаль шинжлэл, инженерийн чиглэлээр суралцах оюутныг төрийн бодлогоор тусгайлан дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Өндөр ёс суртахуун, өндөр мэдлэг боловсролтой багш хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- ШУ, Боловсрол, Хүүхдийн хүмүүжил боловсролын стандартыг бий болгоно.

Монгол соёл, өв уламжлал, их спортыг хөгжүүлж Монгол эх орноо дэлхийд данстай байлгах нь бидний бас нэгэн зорилт болно.

Үүний тулд:

- Соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангана.

- Монгол хүний төлөвшил хөгжлийн эх үндэс болсон түүх, соёл, урлаг, зан заншил, уламжлалыг таниулан сурталчилах үндэстний соёлын цогцолбор төв байгуулна.
- Соёлын байгууллагын барилга, байгууламжийг стандарттай болгож шаардлагатай музей, театрын барилгыг шинээр барьж байгуулна.
- Түүх, палеонтологи, археологийн олдворыг онцгойлон хадгалж хамгаална.
- Соёлын өвийг эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээх зэрэг ажлуудыг үргэлжлүүлнэ.

ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО – ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ

Өнөөдөр манай оронд улс төр, эдийн засаг, эрх зүйн зөв шийдэл гаргахгүй бол инфляци, үнийн өсөлт хяналтаас гарч эдийн засгийн хямрал гүнзгийрч дампуурал, асар их ядуурлын ангал уруу унах бодит аюул тулгараад байна.

Хүн амын үндсэн хэрэгцээг тогтвортой хангасан, өөрийгөө тэтгэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөв, санхүү, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь макро эдийн засгийн хүрээний манай намын үндсэн зорилт байх болно.

Банк санхүүгийн тогтолцооны урт, дунд, богино хугацааны тогтвортой, эрсдэлгүй найдвартай байдлыг чанд хангахуйц олон улсын жишиг, хөгжлийн бодлогын зорилгод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.

Үүний тулд:

- Улсын төсвийн орлого, зарлагын хяналтыг ил тод болгосон шилэн дансны хуулийг сайжруулж, бүх шатны хариуцлагыг дээшлүүлнэ. Төсвийн орлогыг эрс нэмэгдүүлэх дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Мөнгөний бодлогыг бодит эдийн засгийг дэмжихэд чиглүүлнэ
- Монголд үйлдвэрлэж байгаа бараатай ижил төрлийн барааны импортын татварыг нэмэгдүүлж дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.
- Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- Цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлнэ.
- Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан жижиг бизнесийг дэмжинэ.
- Санхүүгийн секторын шинэтгэлийг бодит сектор, тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн бусад салбар, жижиг, дунд бизнесийн өсөлтийг дэмжих, хувийн даатгалын ба хөрөнгө оруулалтын сангууд, хувийн тэтгэврийн сангийн болон зээлийн батлан даалтын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоно.

- Хөрш орнууд болон бусад орнуудын ЗГ-тай байгуулсан худалдааны гэрээнүүдээ шинэчлэх замаар гадаад худалдааны алдагдлыг бууруулж, улмаар тэнцвэржүүлэх бодлого баримтална.
- Олон улсын жишигт нийцсэн давхар даатгал бүхий даатгалын тогтолцоог жинхэнэ утгаар нь бий болгоно.
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Бага-Нуур, Налайх зэрэг хүн ам төвлөрсөн бүс нутгуудад аж үйлдвэрийн парк байгуулах төслийг хүн ам, газар зүйн байршлыг харгалзан өөрчлөн зохион байгуулна.

Уул уурхайн салбараас эдийн засгийн хамаарах хамаарлыг бууруулах, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий олон тулгуурт эдийн засгийг бий болгох нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт байна.

Үүний тулд:

- Уул уурхайн бус экспортыг дэмжиж, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, манлайлалтай боловсруулан хэрэгжүүлнэ. Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын Хөгжлийн сан байгуулна.
- Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах асуудлыг шийдвэрлэнэ.
- Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөж, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэн хэрэглэх боломжийг нэмэгдүүнэ.

ЗУРГАА. ҮЙЛДВЭРЖИЛТ – АМЬДРАЛЫН БАТАЛГАА

Манай орны хөгжлийн гол зүтгүүр нь аж үйлдвэржилт бөгөөд түүнийгээ нягт холбосон зам тээврийн сүлжээ бүхий дэд бүтэцтэй аж үйлдвэрийн цогцолбор байх юм.

Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн цогцолбор зэрэг байна.
- Малын гаралтай түүхий эдэд тулгуурласан Хөнгөн үйлдвэрийн цогцолбор
- Уул уурхайд тулгуурласан Хүнд үйлдвэрийн цогцолбор
- Банк санхүү, харилцаа холбоо, үйлчилгээний салбаруудыг хамарсан Үйлчилгээний цогцолбор

Бүгд Найрамдах Нам Монгол Улсынхаа эдийн засгийн үсрэнгүй хөгжил, ард түмнийхээ чинээлэг амьдралыг хангах ойрын болон дунд, урт хугацааны хөтөлбөртөө аж үйлдвэрийн бүтцийг цогц тогтоцтой байхаар бодож, ~~хүнд~~ үйлдвэрийн цогцолборыг томоохон олборлох үйлдвэрүүдийг дагасан дунд, тэдгээрийг тойрсон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч олон тооны жижиг үйлдвэрүүдийн цогц байхаар төлөвлөж байна.

Жишээ нь: Эрдэнэт, Оюу Толгой, Цагаан Суврагын зэсийн ордуудыг тулгуурласан зэс баяжуулах, цэвэршүүлэх үйлдвэрүүдийг барьж, тэдгээрийг тойруулан зэс утас, зэс хоолой, цахилгаан техник, авто машины сэлбэг, эд ангиуд үйлдвэрлэх олон тооны жижиг дунд үйлдвэрүүд, тэдгээрт үйлчилдэг санхүү, маркетинг, ложистик, худалдааны цогцолборууд байх юм.

Уул уурхайн том төслүүдийг дагаад Эрдэнэт хот шиг орчин үеийн хот, хот маягийн суурин, тосгод байгуулахыг хөрөнгө оруулагчидтай хэлэлцэн тохиролцоно. Ингэснээр Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл эрс буурч, дэд бүтцүүд үүсэх бололцоо бүрдэнэ.

Монгол Улс БНХАУ, ОХУ, Энэтхэг, Казахстан, Япон, БНСУ зэрэг томоохон зах зээлүүдийн дунд оршиж байгаа нь аж үйлдвэрээ хөгжүүлэх манай орны нэгэн том бололцоо билээ. Энэ нь Монгол Улс зөвхөн ашигт малтмалын олборлогч биш харин гүн боловсруулалт хийж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, экспортлогч хүчирхэг гүрэн болох бодит боломжийг нээнэ.

Нэн тэргүүнд стратегийн түүхий эд болох газрын тосоор дотоодынхоо хэрэгцээг хангаж улмаар илүүдлээ экспортлох эрх зүйн боломжтой болохын тулд одоо мөрдөгдөж байгаа “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г халж илүү боловсронгуй хууль боловсруулж батлах шаардлагатай юм. Ингэхдээ бид үндэснийхээ аж ахуйн нэгжүүдээ түлхүү дэмжих бодлого баримтлана.

Манай орны газар зүйн байршил, цаг уурын нөхцөл байдал нь сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах боломжийг олгодгоороо онцлог бөгөөд Эх дэлхийн дулаарлын эсрэг хүлэмжийн хийг бууруулахын төлөө бүх нийтээрээ тэмцэж байгаа өнөөгийн нөхцөлд эрчим хүчний нөөцийн нэг хэсгийг сэргээгдэх эрчим хүчний станц олноор байгуулж бүрдүүлэх нь илүү оновчтой байна. Сэргээгдэх эрчим хүчний бодлогыг татварын орчноор хөхүүлэн дэмжиж, гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэх нь манай тэргүүлэх зорилтын нэг байна. Бизнесийг дэмжсэн татварын шинэчлэл хийж, төсвөөс олгох зээлийн хүүг бууруулж нэг оронтой тоонд оруулан инфляцид хөтлөгдөх бус зохицуулдаг тогтолцоонд шилжинэ.

Ингэснээр нийгмийн жинхэнэ баялаг бүтээж буй аж ахуйн нэгж, ажил олгогч эздүүд ажлын байр бий болгосныхоо төлөө одоогийнх шиг олон тооны татвар, шимтгэл төлөх байдлаар “цээрлэл амсах” биш харин ч шинээр үйлдвэрүүд барих, ажлын байрыг олноор бий болгох сонирхолтой болохоос үүдээд Монголын ард түмний амьдрал эрс сайжирч, Төр түмний холбоо бэхжин ирээдүй рүүгээ тэмүүлэх бидний итгэл үнэмшил улам гэгээлэг болох юм.

ДОЛОО. ХӨДӨӨ АЖ АХУЙ – АЮУЛГҮЙ ХҮНС

Хөдөө аж ахуйн салбарыг хөгжлийн үндсэн зүтгүүр төслийн хэмжээнд авч үзэж мал аж ахуй болон газар тариаланг стратегийн чухал ач холбогдолтой салбар хэмээн үзэж төрөөс онцгойлон дэмжинэ.

Хөдөө аж ахуйн салбарыг бүрдүүлэгч үндсэн хоёр салбар болох мал аж ахуй, газар тариаланг нийт хүн амын хоол хүнс болон эрүүл амьдрах эдийн засгийн гол тэжээгч хүчин зүйл болгож хөгжүүлнэ. Ингэснээр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, гаднаас хамааралгүй болгоно.

Мах сүүний чиглэлийн эрчимжүүлсэн аж ахуйг малын үүлдэр угсааг сайжруулах, малыг эрүүлжүүлэх замаар хөгжүүлэн экспортыг дэмжинэ. Газар тариаланд дэвшилтэт технологи нэвтрүүлж хоршооллын хэлбэрийг төрөөс дэмжинэ.

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг хотуудад МУ-ын хүн амыг хүнсээр хангах 2 жилийн нөөцийг хадгалах өндөр технологид суурилсан, бүрэн автоматжисан хүнсний нөөцийн агуулахуудыг барьж байгуулна. Төрөөс мөнгө гаргаж малчид, тариаланчид, ногоочдоос хүнсний бүтээгдэхүүнийг нь бөөний үнээр худалдан авдаг тогтолцоотой болгоно. Хүнсний нөөцийн агуулахуудаас бөөний болон жижиглэнгийн дэлгүүрийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэж, нөөцийн бүтээгдэхүүнийг тасралтгүй эргэлтэнд байлгана.

Жил бүр хүнсний агуулахад мах бэлдэж нөөцлөн жилийн турш махны үнийг тогтвортой байлгах бөгөөд хот суурин газарт зөвхөн үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүү, сүүн бүтээгдэхүүн худалддаг болгоно.

Хөшигтийн онгоцны буудал ашиглалтанд орсноор хүнд даацийн онгоцоор намарт нь Дундад азийн орнуудаас шинэ ургацын хямд үнэтэй нарийн ногоо, жимс, жимсгэнийг импортлон хүнсний агуулахуудад хадгална. Эдгээр агуулахуудыг түшиглэн төрөл бүрийн хүнсний үйлдвэрлэл бий болохыг төрөөс дэмжинэ. Ингэснээр нөөш, жимсний чанамал, ундаа зэргийг үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүд олноор байгуулагдана.

Хүнсний нөөцийн агуулах байгуулснаар:

- Хүнсний аюулгүй байдал, чанар, стандартыг төр хяналтандаа

- бүрэн байлгах боломж бүрдэнэ
- Хүнсний баталгаат нөөцтэй болно
 - Үнийн хэлбэлзлийг тогтворжүүлэх нэг хүчин зүйл болно
 - Малын хулгайг арилгах гол хүчин зүйл болно

Багануурын Хүнсний нөөцийн агуулахаас Зүүн бүсийн аймгуудыг, Дархан, Эрдэнэтээс Баруун бүсийн аймгуудыг, Улаанбаатараас Төвийн болон Говийн бүсийн аймгуудыг тус тус хангана.

Мөн түүнчлэн:

- Спиртийн үйлдвэрлэлийг төрийн мэдэлд авна.
- Багануурт хүнсний нарийн ногооны хүлэмжийн аж ахуй байгуулна.
- Бүсүүдийн төвд тэжээлийн аж ахуйн цогцолборуудыг байгуулна.
- Хадлан тэжээл бэлтгэх, ургац хураалтын ажлыг чанаржуулж эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжих бодлого боловсруулна.
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлнэ.
- Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг бүрэн боловсруулж, зах зээлд нийлүүлдэг болгоно.
- Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын гадна байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.
- Малын даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг индексжүүлж бүртгэнэ.
- Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт-хонь, ямааны аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.
- Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруула хүйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулна.
- Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.
- Мал эмнэлэг, үржлийн асуудал эрхэлсэн төрийн үйлчилгээний албыг бүх сумдад шинээр байгуулна.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хууль эрх зүйн бодлогоор дэмжинэ.
- Оюутан залуусыг намрын ургац хураалтын ажилд оролцуулж, ажлын хөлсийг олгуулна.
- Удирдах болон технологийн өргөн мэдлэг бүхий механикжуулагч, тариаланч, ногоочдыг бэлтгэх сургалтыг үнэгүй болгоно.

- Хөдөө аж ахуйн мэргэжилтэй оюутан залуусыг шалгарулан авч газар тариалан өндөр хөгжсөн орнууд уруу тодорхой хугацагаар явуулж дадлагажуулна.
- Ойрын 10-н жилд газар тариалангийн талбайг бүрэн усалгаатай болгоно.
- Усалгаатай тариалалт хийх аж ахуйн нэгжид хүүгүй зээл олгоно.
- Цөөн малтай малчид, тариалангийн бага газартай тариаланчдын бизнесийг хамгаалах, зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.

НАЙМ. ДЭД БҮТЭЦ, АРДЫН ОРОН СУУЦ – АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ

Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийг чанартай, хүртээмжтэй нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, бохирдлыг бууруулах менежментийг сайжруулна.

Үүний тулд:

- Бүх аймгийн төвүүдийг холбосон хатуу хучилттай авто замын сүлжээг бий болгоно.
- Хөндлөн тэнхлэгээр “Мянганы төмөр зам” урт хугацааны төслийг боловсруулж, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
- Босоо тэнхлэгээр Замын -Үүд – Алтанбулаг чиглэлд Ази, Европыг холбосон транзит ачаа тээврийн хурдны зам барих ажлыг эхлүүлнэ.
- “Ардын орон сууц” хөтөлбөрийг Концессийн гэрээгээр хэрэгжүүлж бага, дунд орлоготой гэр хорооллын иргэдийг тохилог утаагүй, шөнийн цагаар хямд үнэтэй цахилгаанаар халдаг, цэвэр ус, бохирын системд холбогдсон 300,000 айлын хувийн тохилог сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Орон сууцны зээлийг санхүүжилтын шинэ аргачлалаар орон сууцыг нь барьцаалж 25 жилийн хугацаатайгаар олгоно.
- Орон сууцны нэг гэр бүлд ногдох стандартыг 80 м2 байхаар шинэчлэнэ.
- Гэр хорооллын барилгажуулалтыг дэмжихийн тулд дэд бүтэц инженерийн шугам, сүлжээг улсаас санхүүжүүлэх нөөц боломжийг эрэлхийлэн тухайн төсвийн боломжийг үе шаттайгаар ашиглах төслийг хэрэгжүүлнэ. Ингэснээр агаар, хөрсний бохирдол, эрүүл ахуйн асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэгдэх үндэс суурь тавигдана.
- Хөшигт дахь олон улсын нисэх буудлыг барьж дуусгаснаар улс хоорондын ачаа тээврийн олон улсад өрсөлдөхүйц аж ахуйн нэгжийг олноор байгуулахыг дэмжинэ.
- Олон улсад үйл ажиллагаа явуулдаг Ази – Европыг холбосон интернет провайдер компаниудын ажлыг дэмжинэ.

ЕС. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО – НОГООН ИРЭЭДҮЙ

Байгаль экологийн нэгдсэн тогтолцоог бий болгох замаар орчны тогтвортой байдлыг хангасан, экосистемийн үйл ажиллагааг байгалийнхаа баялгийг зүй зохистой, ариг гамтай, ард түмэндээ үр ашигтайгаар ашиглан өнөө болон хойч үедээ өвлүүлэн үлдээхийн төлөө байх нийгмийг бүтээн байгуулах нь манай намын нэгэн зорилт мөн.

Үүний тулд:

- Томоохон гол, мөрнүүдэд далан байгуулж урсацын тохиргоо хийх замаар усан сан байгуулж бүс нутгийн усны хангамжийг сайжруулна.
- Гүний усны нөөцийг нэмэгдүүлэхийн тулд гүний усны хэрэглээг багасгана.
- Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авч, усны менежментийн цогц бодлогыг “Усны нөөцийн яам” байгуулах замаар хэрэгжүүлнэ.
- Уул уурхай болон бусад томоохон төслийг санхүүжүүлэгч банкууд уг төслийг хэрэгжүүлэгч нь төсөлдөө байгаль орчноо хамгаалах талаар хэр бодитой хөрөнгө, мөнгө тусгасныг нь харгалзан зээл олгодог байх механизмыг бий болгох зэрэг ажлыг хийнэ.
- Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх химийн хорт бодис хэрэглэдэг боловсруулах үйлдвэрүүдийг хот, суурин газраас нүүлгэж үйлдвэрийн болон ахуйн хаягдал усыг цэвэршүүлэн дахин ашиглах технологи нэвтрүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулах.
- Монгол Улсын байгалийн үнэт баялаг болсон хангайн бүсэд ашигт малтмал олборлохыг хуулиар хязгаарлаж, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ.
- Аялал жуулчлалын дэд бүтэц, барилга, байгууламжийг тухайн нутгийн онцлог, нөөцөд тулгуурлан бэхжүүлнэ.
- “Ардын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хот, суурин газруудын агаар, хөрс, усны бохирдолын асуудлыг шийднэ.

АРАВ. БАТЛАН ХАМГААЛАХ – САЙН ХӨРШИЙН ТҮНШЛЭЛ

Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд идэвхтэй оролцож, урт, дунд хугацааны хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх замаар Зэвсэгт хүчнийхээ шинэчлэлийг гүнзгийрүүлж, түүнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ.

Үүний тулд:

- Батлан хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан төрийн батлан хамгаалах бодлогыг шинэчлэнэ.
- Зэвсэгт хүчний нэгдмэл байдлыг хангаж, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн зэвсэгт хүчинтэй болно.
- Хил хамгаалах бодлогыг шинээр тодорхойлж, улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлнэ.
- НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа манай ЗХ-ий чадавхийг улам бэхжүүлнэ.
- Армид цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлж, хүн бүрт тусгай мэргэжил эзэмшүүлнэ.
- Цэргийн албан хаагчдыг Эх орныхоо бүтээн байгуулалтад татан оролцуулна.

АРВАН НЭГ. ГАДААД ХАРИЛЦАА – ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсаг харилцаагаа өргөжүүлнэ.

Үүний тулд :

- Улс төр, эдийн засгийн болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлнэ.
- Бүс нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцоно.
- Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдийнхээ гадаадад зорчих нөхцлийг хөнгөвчлөн, эх орноо гадаадад сурталчилан таниулах зэрэг ажлыг эрчимтэй хийнэ.
- Гадаад бодлогын үндсэн зарчим болох эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах, энх тайвнаар зэрэгцэн орших хөгжлийн бодлого явуулна.
- Эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологи, боловсрол, спорт, хүмүүнлэгийн болон бусад бүхий л салбарт гадаад харилцаагаа улам эрчимжүүлнэ.
- Дэлхийн энх тайван, хөгжил дэвшлийн төлөө гадаад бодлогыг гүнзгийрүүлнэ.
- Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд дэлхийн улс орнуудтай найрсагаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар

- хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байддалд орохоос сэрэмжилнэ.
- Далайн тээврийн асуудлыг төрийн бүрэн эрх мэдэлд авч, ~~далбаа~~ ашиглалтын орлогыг нэмэгдүүлнэ.
- ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцаж, түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзан сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- АНУ, Япон, Европын холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.
- Ази, Номхон далайн бүс нутагт хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.
- Үндэсний компани, аж ахуйн нэгжүүдийг гадаадад хөрөнгө оруулах, олон улсын банк, санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- Гадаадад байгаа Монгол Улсын иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдийг эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжих, гадаадад гэрээгээр ажиллагсадын нийгмийн хамгааллыг сайжруулах, Монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлого хэрэгжүүлнэ.
- Дэлхийн улс орнуудтай дипломат харилцааг шинэ шатанд гаргаж концессийн гэрээг эдийн засгийн бодлогын суурь болгох үндсийг тавина.
- Олон улсын харилцаанд эдийн засгийн хамтын ажиллагааг түлхүү анхаарч ажиллана.
- Эх орноо бүх талаар гадаад ертөнцөд сурталчлан таниулж, түүх, соёлын үнэт зүйлс, байгалийн өвийг хамгаалах, сэргээх талаар гадаад улсын хийгээд олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

БҮГД НАЙРАМДАХ НАМЫН ЕРӨНХИЙ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.27 № 715

танай _____-ны № _____-т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Бүгд Найрамдах намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Бүгд Найрамдах намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Бүгд Найрамдах намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Бүгд Найрамдах намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД